



ТАТВАРЫН ТАЛААРХ ИЛЭН ДАЛАНГҮЙ ЯРИА



УИХ-д өргөн барьсан хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн төсөлд тусгасан хасагдах зардлууд

Хуулийн этгээдийн орлогын албан татварын хуулийн төсөлд одоогийн мөрдөж буй хуульд бүхэлд нь буюу хэсэгчлэн зөвшөөрөөгүй зарим зардлуудыг хасагдах зардалд тооцохоор тусгалаа.

Дараах хүснэгтээс хуулийн төсөлд шинээр нэмэгдэж буй хасагдах болон хасагдахгүй зардлуудын нэр төрөл, тэдгээрт тооцох хязгаарлалтыг үзнэ үү.

Хасагдах зардлууд	Хасагдах зардлуудад тогтоосон хязгаар
<ul style="list-style-type: none"> Санхүүгийн түрээсийн төлбөрийн хүү Зар сурталчилгааны зардал Ажиллагсадаа олгосон шагнал, урамшуулал Байр, орон сууцны хөлсний болон унаа, хоол, түлшний үнийн хөнгөлөлт Мэргэжлийн сонин сэтгүүлийн захиалга Импортын бараа, материалын гаалийн албан татвар Ажиллагсдын сургалт, давтан сургалтын зардал (дотоодын жишгээс хэтрэхгүй дүн) Албан томилолтын зардал (төрийн албан хаагчийн жишгээр тооцно) Үр бордоо, мал, амьтны гэжээл, эм тарилга Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал Хөдөлмөр хамгааллын зардал Холбоо, бичиг хэрэг, цэвэрлэгээ, харуул, хамгаалалтын зардал Гамшгийн улмаас учирсан хохирол Бараа, материалын хэвийн хорогдол Програм хангамжийн бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулсан хөрөнгө Ашигт малтмалын лиценз эзэмшигчийн байгаль орчныг нөхөн сэргээх зорилгоор төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө Банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө 	<ul style="list-style-type: none"> Сайн дурын даатгалын хураамжийн дүн татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх Санхүүгийн түрээсийн төлбөр төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн дүн санхүүгийн түрээсийн төлбөрийн 5 хувиас хэтрэхгүй байх Үл хөдлөх эд хөрөнгийн урсгал засварын зардал тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгийн 2 хувиас хэтрэхгүй байх Хөдлөх эд хөрөнгийн урсгал засварын зардал тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй байх

Дараагийн дугаартаа үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн талаар мэдээнэ.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэчлэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн арванхоёрдугаар хэсэг юм. Та бүхэн уг цуврал болон өргөн барьсан хуулиудын төслийн электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), ҮТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно. Иргэдээс санал авах зорилгоор дээрх вэб сайтаас гадна олны танил болсон бусад вэб сайтуудад уг нийтлэлийг мөн гаргаж байгаа юм. Та бүхэн санал, сэтгэгдлээ үлдээнэ үү.